

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Улаанбаатар хот, Налайх дүүрэг, Монгол улс

Зарласан огноо: 2026/08/17

Материал хүлээн авах эцсийн хугацаа: 2026/08/31

Ажил эхлэх хугацаа: 2026/09

Гэрээний төрөл, хугацаа: 6 сар / Төслийн үндсэн дээр

Цалин: Цалинг ажилтны боловсрол, мэргэжлийн ур чадвар, ажлын туршлагад үндэслэн харилцан тохиролцоно.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ТӨВИЙН МЕНЕЖЕР

(Төслийн ажилтан)

Үндсэн үүрэг:

- Зах зээлийн эрэлт, салбарын хөгжлийн чиг хандлагад үндэслэн Төвийн стратеги, жилийн ажлын төлөвлөгөө, сургалтын тэргүүлэх чиглэлийг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Уул уурхай, үйлдвэрлэлийн салбарын байгууллагуудтай урт хугацааны хамтын ажиллагааг хөгжүүлж, тэдний сургалтын хэрэгцээг тодорхойлон, тохирсон санал боловсруулах;
- Сургалтын төлөвлөлт, хуваарь, хэрэгжилтийг нэгдсэн байдлаар удирдан зохион байгуулж, багш, оролцогч болон бусад холбогдох талуудын уялдаа холбоог хангаж ажиллах;
- Төсөв төлөвлөх, зардлыг хянах зэргээр Төвийн санхүүгийн гүйцэтгэлийг удирдан, орлогын зорилтын биелэлтийг хангах;
- Оролцогчийн санал хүсэлт, гүйцэтгэлийн үзүүлэлтэд үндэслэн сургалтын чанарыг тасралтгүй сайжруулж, давтагдах, өргөжих боломжтой сургалтын хэлбэрийг хөгжүүлэх.

Тавигдах шаардлага:

- Бизнесийн удирдлага, менежмент, төслийн удирдлага, боловсрол болон холбогдох чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй байх.
- Сургалтын менежмент, төслийн удирдлага, бизнесийн хөгжлийн чиглэлээр 3 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх;
- Байгууллага болон салбар түншүүдтэй хамтран ажилласан туршлагатай байх;
- Зохион байгуулах, төлөвлөх, хэлэлцээр хийх, тайлагнах ур чадвартай байх;
- Харилцааны өндөр ур чадвартай, дүн шинжилгээ хийх чадвартай, бизнесийн сэтгэлгээтэй байх;
- Англи болон монгол хэлний аман болон бичгийн харилцааны өндөр ур чадвартай байх.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар (CV)
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа – 2 хувь

Анкет хүлээн авах, холбоо барих:

☑ Та баримт бичгээ англи хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж recruitment@gmit.edu.mn хаягаар бидэнд ирүүлнэ үү. (Хуулбарыг furthertrainingcenter@gmit.edu.mn хаягаар мөн илгээнэ)

☎ Утас: +976 7023-2090

🌐 Цахим хуудас: www.gmit.edu.mn

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.